



Тендерийн урилга

Огноо: 2015/11/16

Материал хүлээж авах сүүлийн хугацаа: 2015/12/16 09:00

Тендер шалгаруулалтын нэр: Чингэлтэй дүүргийн **Нийгмийн даатгалын тасгийн барилга Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 13-р хороо 17 дугаар сургуулийн баруун хойно./**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧД/БУ/15-01**

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын тасгийн барилга барих тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкны 340000047120 тоот дансанд нь 100000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 онуудын жилийн борлуулалтын орлого 300,0 сая төгрөгөөс багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал божож буй үнийн дүнгийн 40 хувиас багагүй.**
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил / 2014, 2015 оны эхний хагас жил/.
 - Ижил төстэй ажлын туршлага: **Сүүлийн 2 жил буюу 2014,2015 онуудад доод тал нь нэг удаа 200,0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлыг ерөнхий гүйцэтгэгчээр гүйцэтгэсэн байна.**
 - **Барилга угсралтын иж бүрэн ажил эрхлэх эрх бүхий хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх. Барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж дуустал хугацаанд хүчинтэй байна. /Захиалагчийн барилгын ажлыг гүйцэтгэхүйц иж бүрэн зөвшөөрөлтэй байна./**
 - **Тендерийн хамт Санал болгож буй үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**

Тендерийг **2015 оны 12-р сарын 16** -ний өдрийн **09** цаг **00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2015 оны 12-р сарын 16** -ний өдрийн 10 цагт НДЕГ-н 701 тоотод болно.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Давуу эрх тооцохгүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газар, санхүү бүртгэлийн газар, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Харилцах утас: 328030-609